



**ХЭНТИЙ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ЕСДҮГЭЭР ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2022 оны 01 сарын 21 өдөр

Дугаар 06

Чингис хот

**“Хэнтий аймгийн аялал жуулчлалыг  
хөгжүүлэх хөтөлбөр-2030”  
батлах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, 48.2 дахь хэсэг, 35 дугаар зүйлийн 35.1.8 дахь заалт, Аялал жуулчлалын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Есдүгээр Хуралдаанаас **ТОГТООХ нь :**

1. “Хэнтий аймгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх хөтөлбөр-2030” дунд хугацааны бодлогын баримт бичгийг хавсралтаар баталсугай.
2. “Хэнтий аймгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх хөтөлбөр-2030” дунд хугацааны бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх, удирдлага зохион байгуулалтаар хангах, шаардагдах хөрөнгийг улс, орон нутгийн төсөвт тусгах, хувийн хэвшил, гадаад дотоодын хөрөнгө оруулалт, хандив тусламжийг татах, шаардлагатай арга хэмжээ авч, үр дүнг жил бүрийн 12 дугаар сарын 05-ны дотор тайлагнаж ажиллахыг аймгийн Засаг дарга /Чогсомжав/-д үүрэг болгосугай.
3. “Хэнтий аймгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх хөтөлбөр-2030”-ийг өөрийн сум орон нутагт хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, үр дүнг тооцож ажиллахыг сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга нарт үүрэг болгосугай.
4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Байгаль орчин, аялал жуулчлал, хөдөөгийн хөгжлийн хороонд үүрэг болгосугай.

ДАРГА



ГХЭРЛЭНЧУЛУУН

## **ХЭНТИЙ АЙМГИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР-2030** **Дунд хугацааны бодлогын баримт бичиг (2022-2030 он)**

### **НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

1.1. Улсын хэмжээнд аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар бодлогын олон баримт бичгүүд хэрэгжиж байгаагийн зэрэгцээ Үндэсний хөгжлийн цогц бодлогод аялал жуулчлалын салбарын хөгжлийг эрчимжүүлэх талаар олон зорилтууд дэвшүүлэгдээд байна. Монгол улсын Засгийн газраас Хэнтий аймгийг түүхэн аялал жуулчлалын бүс нутаг болгон хөгжүүлж байгаа билээ.

1.2. Аялал жуулчлалын салбарыг Хэнтий нутгийн хөгжил, эдийн засгийн гол хөшүүрэг болгох үүднээс аялал жуулчлалын салбарт шинээр бүтээгдэхүүн үйлчилгээг нэмэгдүүлэх, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, улсдаа болон олон улсад өрсөлдөх чадварыг дээшлүүлэх нь энэхүү "Хэнтий аймгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх хөтөлбөр 2030"-ыг / цаашид хөтөлбөр гэх / боловсруулах үндэслэл болно.

### **ХОЁР. ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ХЭРЭГЖИХ ХУГАЦАА, САНХҮҮЖИЛТ,**

#### **2.1. Хөтөлбөрийн зорилго**

Хэнтий аймагт түүхэн аялал жуулчлалыг үе шаттайгаар хөгжүүлэх ажлыг зохион байгуулж, аялал жуулчлалын урсгалыг нэмэгдүүлэн эдийн засгийн өсөлтийг бий болгож, Мянганы суут хүн - Их эзэн Чингис хааны төрсөн нутаг Хан Хэнтий аймаг нь хамаг Монголчуудын хүндэтгэл, бахархлын өлгий нутаг байхад оршино.

#### **2.2. Хөтөлбөрийн зорилт**

2.2.1. Түүхэн аялал жуулчлалыг хөгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх, нэгдсэн бодлогоор хангах;

2.2.2. Монголын нууц товчоонд дурдагдсан түүхэн ач холбогдолтой газар, нутгуудыг тодорхойлж, аялал жуулчлалын дэд бүтцийг хөгжүүлж, жуулчин хүлээн авах хүчин чадлыг нэмэгдүүлэх;

2.2.3. Түүх, нүүдэлчдийн өв соёл, байгаль, орон нутгийн онцлогт тулгуурласан, ОУ-ын стандартын түвшинд хүрсэн аялал жуулчлалын бүтээгдэхүүн, зочлох үйлчилгээтэй, жуулчдын сэтгэлийг татсан өлгий нутгийг хөгжүүлэх;

2.2.4. Аялал жуулчлалын салбарт дэвшилтэт технологийг нэвтрүүлэн цахим аялал жуулчлалыг хөгжүүлж, чанар, хүртээмжийг сайжруулах;

2.2.5. Аялал жуулчлалын салбарын судалгаа шинжилгээ, мэдээллийн тогтолцоог сайжруулж дотоод, гадаад хамтын ажиллагаа, маркетинг сурталчилгааг эрчимжүүлэх;

2.2.6. Нутгийн иргэдийн оролцоотой тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлж иргэдийн амьжиргааг сайжруулж орон нутгийн нийгэм, эдийн засгийн өгөөжийг нэмэгдүүлэх;

2.2.7. Аялал жуулчлалын сайн засаглал, шилдэг менежментийг бэхжүүлэх;

#### **2.3. Хэрэгжих хугацаа**

Хөтөлбөрийг 2022-2030 оны хооронд дараах үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

1 дүгээр үе шат - Эхлэл, бүтээн байгуулалтын үе шат 2022-2024 он

2 дугаар үе шат - Эрчимтэй хөгжлийн үе шат 2025-2030 он

#### **2.4. Санхүүжилт**

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ.

- Улсын болон орон нутгийн төсөв
- Олон улсын төсөл, хөтөлбөр
- Олон улсын зээл, тусламж
- Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт
- Засгийн газрын тусгай сангууд
- Орон нутгийн хөгжлийн сан
- Хувийн хөрөнгө оруулалт
- Хуулиар зөвшөөрөгдсөн бусад эх үүсвэр



#### **ГУРАВ. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ**

##### **3.1. “Түүхэн аялал жуулчлалыг хөгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх, нэгдсэн бодлогоор хангах” зорилтын хүрээнд:**

3.1.1. “Чингис хаан” судлалыг хөгжүүлж, бие даасан салбар шинжлэх ухаан болгох эрх зүйн орчныг бүрдүүлэх, бодлого боловсруулж батлуулахад дэмжлэг үзүүлэх

3.1.2. Чингис хаан судлалын эрдэм шинжилгээний хурал, судалгааны ажлуудыг санхүүжүүлэх “Чингис хаан” судлалын сан байгуулах;

3.1.3. “Чингис хаан ба Монголын эзэнт гүрэн” цахим мэдээллийн бааз үүсгэхэд хамтран ажиллах (англи, монгол хэлээр);

3.1.4. “Их эзэн Чингис хаан-Монголын нууц товчоо түүхт нутгаар” баримтат кино бүтээх ажлыг судлах

3.1.5. “Их эзэн Чингис хаан” Монголчуудын бахархал – ёслол, хүндэтгэлийн журам боловсруулан хэрэгжүүлэхэд хамтран ажиллах

3.1.6. Чингис хаантай холбоотой аливаа нэр нэршлийг бизнесийн зорилгоор зүй зохистой ашиглах журам боловсруулж батлуулах тал дээр санал уламжлах

3.1.7. Монголын их хаад, хатад, суут хүмүүс, түүхэн газар нутаг, эд өлгийн зүйлсийн нэрийг зөв галиглах, нэг нэршилд оруулах, НҮБ-ын албан ёсны таван хэлээр галигласан толь бичиг гаргах ажилд хамтран ажиллах

3.1.8. “Их Эзэн Чингис хаан, Монголын нууц товчоо” олон улсын эрдэм шинжилгээний хурал, уулзалтуудыг зохион байгуулахад хамтран ажиллах

##### **3.2. “Монголын нууц товчоонд дурьдагдсан түүхэн ач холбогдолтой газар, нутгуудыг тодорхойлж, аялал жуулчлалын дэд бүтцийг хөгжүүлж, жуулчин хүлээн авах хүчин чадлыг нэмэгдүүлэх” зорилтын хүрээнд:**

3.2.1. Тогтвортой аялал жуулчлалын хөгжүүлэх төслийн хүрээнд Чингис хаан цогцолбор-ыг байгуулах төслийг хэрэгжүүлж ашиглалтанд оруулах / 263 га газар /

3.2.2. Хатуу хог хаягдлын байгууламжийн барилгын ажлыг эхлүүлж ашиглалтанд оруулах /Дадал сум/

3.2.3. Хэрлэн суманд инкубатор байгуулж ашиглалтанд оруулах

3.2.4. Шилэн кабелийн сүлжээг холбож интернэт орчинг бий болгоно / Дадал сумын төвөөс – Чингис хаан цогцолбор-7км /

3.2.5. Сумын төвийн доторх хатуу хучилттай 3.5 км автозам барьж ашиглалтанд оруулах /Дадал сум/

3.2.6. Спорт цогцолборын барилгын ажлыг ашиглалтанд хүлээн авч тохижилтыг хийж дуусгах /Дадал сум/

3.2.7. “Чингис хаан - Монголын нууц” товчоо хүүхэд, залуучуудын соёл амралтын хүрээлэн байгуулах / Дадал сум /

- 3.2.8. Аялал жуулчлалын гудамж төслийг хэрэгжүүлэх / Дадал сум /
- 3.2.9. “Их хуралдайн орд өргөө” цогцолбор төслийг хэрэгжүүлэх зураг, төсөв, барилгын ажил, дотоод, гадаад тохижилтыг хүлээн авч ашиглалтанд оруулах /Биндэр сум /
- 3.2.10. “Их Хуралдайн орд өргөө “ цогцолборт шилэн кабелийн сүлжээг холбож интернэт орчин үүсгэнэ. (Биндэр сумын төвөөс – “Их хуралдайн орд өргөө” цогцолбор-3.3 км) / Биндэр сум /
- 3.2.11. “Их хуралдайн орд өргөө” цогцолборыг эрчим хүчинд холбох-2 км /Биндэр сум /
- 3.2.12. Биндэр сумын төвөөс “Их хуралдайн орд өргөө” цогцолбор чиглэлийн 3 км хатуу хучилттай автозам, автомашины зогсоолын зураг төсөв, барилгын ажил, тохижилтыг дуусгаж ашиглалтанд оруулах
- 3.2.13. “Андгай” дуулалт жүжгээр уран сайхны кино хийж олон нийтэд хүргэх / Батноров сум /
- 3.2.14. “Тэнгэрийн андгай” хөшөөний тохижилтын ажлыг дуусгаж ашиглалтанд оруулах / Батноров сум /
- 3.2.15. Халх даяар алдартай Дархан Тожилын судалгааны материалд суурилсан зурагт тайлбартай цомогийг Монгол, Англи хэл дээр гаргаж олон улсад сурталчлах / Батноров сум /
- 3.2.16. Баян-Адарга сумын Хүннүгийн үеийн олдворт суурилсан танхим үзүүлэн бий болгох ажлыг судлаж эхлүүлэх
- 3.2.17. “Тэнгэрийн андгай” хөшөөт цогцолборыг эрчим хүчинд холбох /Батноров сум/
- 3.2.18. Шилэн кабелийн сүлжээ татаж хөшөөний орчимд интернэт орчинг бий болгох / Батноров сумын төвөөс “Тэнгэрийн андгай” хөшөө хүртэл-13 км /
- 3.2.19. Батноров сумаас “Тэнгэрийн Андгай ” хөшөө хүртэл хатуу хучилттай автозам, авто зогсоолын зураг төсөв, тохижилтыг дуусгаж ашиглалтанд оруулах
- 3.2.20. “Шихихутаг-Нууц товчоо” цогцолборыг байгуулах барилгын ажлыг хүлээн авч ашиглалтанд оруулах / Норовлин сум /
- 3.2.21. “Шихихутаг- Нууц товчоо” цогцолборын дотоод, гадаад тохижилтын ажлыг хүлээн авч ашиглалтанд оруулах
- 3.2.22. “Шихихутаг- Нууц товчоо” цогцолборыг эрчим хүчинд холбох /Норовлин сум/
- 3.2.23. Шилэн кабелийн сүлжээг цогцолборын орчимд бий болгох ажлыг дуусган ашиглалтанд хүлээн авах / Норовлин сумын төвөөс –Шихихутаг-Нууц товчоо цогцолбор-4 км /
- 3.2.24. Норовлин сумаас “Шихихутаг-Нууц товчоо” цогцолбор чиглэлийн 3.5 км хатуу хучилттай автозам, авто зогсоолын зураг төсөв, барилгын ажил, тохижилтыг дуусган хүлээн авч ашиглалатнд оруулан олон нийтэд сурталчлах
- 3.2.25. Монголын Далд уурхайн музей, сургалт, судалгаа, аялал жуулчлалын төв байгуулах, үйл ажиллагааг хүлээн авч ашиглалтанд оруулан үйл ажиллагааг эхлүүлэх / Бэрх /
- 3.2.26. Монголын Далд уурхайн музей, сургалт, судалгаа, аялал жуулчлалын төвийн барилгын ажил, гадаад тохижилтыг хүлээн авч олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулах
- 3.2.27. Монголын Далд уурхайн музей, сургалт, судалгаа, аялал жуулчлалын төв рүү шилэн кабелийн сүлжээ татаж интернэт орчин бий болгох / 2 км /
- 3.2.28. “Монголын нууц товчоо” цогцолбор бүтээн байгуулалтын төсөл хэрэгжүүлэх ашиглалтанд оруулах / Дэлгэрхаан сум /
- 3.2.29. Хар зүрхний Хөх нуурын аялал жуулчлалын бүс нутгийг төвийн эрчим хүчний нэгдсэн системд холбох ажлыг судлах / Цэнхэрмандал сум /

- 3.2.30. Аялал жуулчлалын мэдээллийн төв байгуулж аймаг орон нутгаа сурталчлах / Чингис хот /
- 3.2.31. “Чингис хаан - Монголын эзэнт гүрэн” түүхэн аялал жуулчлалын соёл амралтын хүрээлэн байгуулан гадаад дотоодын жуулчдад орон нутгаа сурталчлан ажиллах / Чингис хот /
- 3.2.32. Аялал жуулчлал гудамж төсөл хэрэгжүүлэх / Чингис хот /
- 3.2.33. Гүрмийн нуур-ын физик химийн судалгаа, ТЭЗҮ боловсруулах ажлыг эхлүүлэх / Баян-Овоо сум /
- 3.2.34. Гүрмийн нуур - амралт, рашаан сувиллын цогцолбор байгуулах ажлын зураг төсвийг боловсруулах / Баян-Овоо сум /
- 3.2.35. Аялал жуулчлалын гол чиглэлийн автозам дагуу түр буудаллах цэг байгуулах /Цэнхэрмандал, Дэлгэрхаан, Батноров, Норовлин, Өмнөдэлгэр, Жаргалтхаан/
- 3.2.36. Хардэл жанжин бээс М.Пүрэвжавын дурсгалын цогцолбор, аялал жуулчлалын төв байгуулж сум орон нутгаа сурталчлах / Галшар сум /
- 3.2.37. Гадаад, дотоодын жуулчид олноор зорин очиж буй газар нутгуудад нэгдсэн отоглох цэг, тэмдэг, тэмдэглэгээ, мэдээллийн самбар, хогийн цэг, ариун цэврийн газар байгуулах / Дадал, Биндэр, Баян-Адрага, Батширээт, Норовлин, Батноров сумдууд /
- 3.2.38. Жуулчид гол зорих газруудад ариун цэврийн газар байгуулах /Өмнөдэлгэр сум /
- 3.2.39. Балданбрайвун хийдийн засвар, тохижилт хийх
- 3.2.40. Хангал нуур орчмын тохижилт / Өмнөдэлгэр сум /
- 3.2.41. Өвөр элгэний гол, Хүчирийн гарам, Баянгол, Өлзийт гарам, Жаргалант гол, Зуслан толгойн гарам / Жижиг гүүр, шороон далан байгуулах Өмнөдэлгэр сум /
- 3.2.42. Чингис хот- Бэрх- Норовлин- Дадал сум чиглэсэн 258 км хатуу хучилттай автозам барих нууц товчоо зам төслийг хэрэгжүүлэх, дуусгах
- 3.2.43. “Дэлүүн болдог” нисэх онгоцны буудлаас аялал жуулчлалын гудамж хүртэлх 8 км хатуу хучилттай автозамын барилгын ажлыг эхлүүлж ашиглалтанд оруулах / жижиг гүүр / - / Дадал сум /
- 3.2.44. “Дэлүүн болдог” онгоцны буудлын шинэчлэлт, талбайн тохижилтыг хүлээн авах - / Дадал сум /
- 3.2.45. “Өндөрхаан” нисэх онгоцны буудлыг шинэчлэн ашиглалтанд оруулах / Чингис хот /
- 3.2.46. Батширээт сум – Эгийн голын гүүрийн засвар / шинэ гүүр /
- 3.2.47. Нэвтрэх цэгүүдийг автоматжуулах ТЭЗҮ, цахимжуулалт / Өмнөдэлгэр, Дадал, Биндэр, Цэнхэрмандал, Дэлгэрхаан сумдууд /
- 3.2.48. Олон улсын стандартад нийцсэн зочид буудал, жуулчны бааз байгуулах ажлыг дэмжиж хамтран ажиллах / Дадал, Биндэр, Бэрх, Норовлин, Батноров, Баян-Овоо, Дэлгэрхаан, Цэнхэрмандал сумдууд /
- 3.2.49. Олон улсын стандартад нийцсэн зочид буудал, жуулчны бааз байгуулах ажлыг дэмжиж хамтран ажиллах / Дадал, Биндэр, Бэрх, Норовлин, Батноров, Баян-Овоо, Дэлгэрхаан, Цэнхэрмандал сумдууд /
- 3.2.50. Сүлжээ буудал, ресторан, хоолны газруудын салбар байгуулах ажлыг дэмжиж хамтран ажиллах / Чингис, Дадал, Биндэр, Батноров, Бэрх, Норовлин сумдууд /
- 3.2.51. Аялал жуулчлал, ногоон хот төлөвлөлтийн шийдэл бүхий хүн амын нутагшил суурьшлын хөгжлийн ерөнхий төлөвлөлтийг хийлгүүлэн хүлээн авч төлөвлөгөө гаргах / Дадал, Биндэр, Батноров, Норовлин, Дэлгэрхаан, Бэрх, Баян-Овоо сумдууд /
- 3.2.52. Аялал жуулчлалын байршуулах хэрэгслийн нарийвчилсан байршлын зураг, төлөвлөгөөг мэргэжлийн байгууллагаар хийлгүүлэх ажлыг зохион байгуулах

3.2.53. Инженерийн дэд бүтэц, шугам сүлжээнд холбох ажлыг зохион байгуулж мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах / Биндэр, Батноров, Норовлин, Дэлгэрхаан, Дадал, Өмнөдэлгэр сумдууд /

3.2.54. Гудамж, талбайн гэрэлтүүлэг, камержуулалтын ажлыг шат дараатайгаар зохион байгуулах / Биндэр, Батноров, Норовлин, Дэлгэрхаан, Бэрх, Дадал, Чингис хот /

3.2.55. Хатуу хог хаягдлын төслийг хэрэгжүүлэх ажлыг эхлүүлэх / хатуу хог хаягдлын байгууламж 18 сумын хэмжээнд /

3.2.56. Цанын бааз байгуулж өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлнэ. / Биндэр сум /

3.2.57. Сумын төв болон Аварга тосон амралтын цэвэрлэх байгууламж, татуургын шугам татах ажлыг судалж хэрэгжүүлэх / Дэлгэрхаан сум /

3.2.58. Монголын нууц товчоог цэнгүүлэх ёслол хүндэтгэлийн арга хэмжээг жил бүр зохион байгуулах / Дэлгэрхаан сум /

3.2.59. Сумын инженерийн шугам сүлжээ, усан хангамж, ариутгах татуургын ажлыг эхлүүлж ашиглалт анд оруулах / Дадал сум /

3.2.60. Морин тойруулгын цогцолбор байгуулж сум орон нутгаа гадаад, дотоодод сурталчлах ажлыг эхлүүлэх / Баянхутаг сум /

3.2.61. Жаргалтхаан сумаас Дэлгэрхаан сум чиглэлд хатуу хучилттай авто замын зураг төсвийг боловсруулж, ашиглалтанд оруулах / 60 км /

3.2.62. Үндэсний өв соёлын шагайн харвааны “Хөдөө арлын тойром”-ыг жил бүр зохион байгуулах / Дэлгэрхаан сум /

3.2.63. Чингис хотоос Бор-Өндөр хүртэл хатуу хучилттай авто зам барих зураг төсөв, автозамын барилгын ажлыг эхлүүлэх

3.2.64. Жаргалтхаан суманд аялал жуулчлалын мэдээллийн төв байгуулах аймаг орон нутгийн мэдээллийг түгээх, сурталчлах

**3.3. “Түүх, нүүдэлчдийн өв соёл, байгаль, орон нутгийн онцлогт тулгуурласан, ОУ-ын стандартын түвшинд хүрсэн аялал жуулчлалын бүтээгдэхүүн, зочлох үйлчилгээтэй, жуулчдын сэтгэлийг татсан өлгий нутгийг хөгжүүлэх” зорилтын хүрээнд:**

3.3.1. Аялал жуулчлал зочлох үйлчилгээ, хөтөч тайлбарлагчийн мэргэжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлж сургалтыг зохион байгуулах / Чингис хот /

3.3.2. Аялал жуулчлалын мэргэжлийн холбоод, байгууллагуудыг дэмжих, хамтран ажиллах

3.3.3. Аялал жуулчлалын орон нутгийн хөтөч, музейн тайлбарлагч бэлтгэх сургалтыг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулах / Дадал сум /

3.3.4. Аялал жуулчлалын салбарын мэргэжлийн байгууллагуудад зориулсан товхимол, ном, танилцуулгууд хэвлүүлэх

3.3.5. Зорих газрын аяллын удирдамж, дүрэм журмыг боловсруулах аялагчдад сурталчилж ажиллах / Дадал сум /

3.3.6. Жуулчдын аюулгүй байдал ба дэмжлэг туслалцаа хөтөлбөрийг холбогдох байгууллагатай хамтран хэрэгжүүлэх

3.3.7. Эрүүл мэндийн анхны тусламж, үйлчилгээний сургалт зохион байгуулах / Аялал жуулчлалын салбар /

3.3.8. Эрүүл мэндийн анхны тусламж, үйлчилгээ хөтөлбөрийг мэргэжлийн байгууллагатай хамтран хэрэгжүүлэх / Эрүүл мэндийн салбар /

3.3.9. БОАЖЯ–ны баталсан Аялал жуулчлалын зочлох үйлчилгээний сургалтуудыг зохион байгуулах хамтран ажиллаж зохион байгуулалтыг хийх

- 3.3.10. Зочид буудлын зэрэглэл тогтоох стандартыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах
- 3.3.11. “Жуулчны бааз, амралтын газар, гэр буудлын стандартыг хэрэгжүүлэх, зэрэглэл тогтоох ажлыг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулах
- 3.3.12. “Их эзэн Чингис - Монголын Эзэнт Гүрэн” виртуал музей, уран зургийн галерей байгуулах ажлыг судлах мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах / Дадал сум/
- 3.3.13. Батноров, Норовлин, Биндэр, Бэрх, Чингис, Баянхутаг сумдын музейн үзмэрийг нэмэгдүүлэх, сэргээн засварлах
- 3.3.14. Чингис хаан одонт, төрийн шагналт, урлагийн гавьяат зүтгэлтэн, хөгжмийн зохиолч, Б.Шаравын нэрэмжит “Сэрсэн тал” хөгжмийн наадмыг зохион байгуулах, гэр урланг тохижуулах ажлыг эхлүүлэх / Жаргалтхаан сум /
- 3.3.15. “Чингис хаан –Монголын нууц товчоо хүүхдийн кино болон олон ангит кино бүтээлүүдийг туурвих ажлыг судлах
- 3.3.16. “Монгол хатад” кино бүтээл туурвих ажлын хэсгийг байгуулах судалгаа хийх
- 3.3.17. Чингисийн морьт цэргийн шоу үзүүлбэр төслийг хэрэгжүүлэх ажлын хэсгийг байгуулах зохион байгуулалтын талаар төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх / Баянхутаг сум /
- 3.3.18. Жуулчдад зориулсан үндэстэн ястан, нүүдэлчдийн ахуй амьдралыг илэрхийлсэн ардын урлагийн хөтөлбөрийг боловсруулах ажлын хэсгийг байгуулах төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэх
- 3.3.19. “Их хуралдай” ёслол, хүндэтгэлийн хөтөлбөрийг боловсруулж батлуулах–МУ-ын үндэсний эвент болгох ажлыг эхлүүлэх / Биндэр сум /
- 3.3.20. Дэлхийн түүхийг өөрчилсөн “Тэмүүжин-Боорчи”-ийн нөхөрлөл эвентийг зохион байгуулах ажлыг судалж хөтөлбөр төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх / “Андлал нөхөрлөлийн баталгаа” гэрэгэ / батлуулах / Батноров сум /
- 3.3.21. “Шихихутаг-Нууц товчоо” цогцолборын үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулж батлуулах / Норовлин сум /
- 3.3.22. Их эзэн Чингис хааны мэндэлсэн өдөрт зориулсан Монгол түмний Их хүмүүн үндэсний хэмжээний эвент арга хэмжээ зохион байгуулах / Дадал сум /
- 3.3.23. “Чингис фестиваль” олон улсын хүүхдийн урлагийн наадам зохион байгуулах / Чингис хот /
- 3.3.24. Талын түмэн адууны баяр эвент арга хэмжээ зохион байгуулах / Батноров сум /
- 3.3.25. “Ёохор” наадам зохион байгуулах / Батширээт сум /
- 3.3.26. “Олон улсын Марафон” гүйлт зохион байгуулах / Биндэр сум /
- 3.3.27. “Монгол хатад” эвент арга хэмжээ зохион байгуулах / Баян-Адрага сум /
- 3.3.28. Эвент хөтөлбөрийн нэгдсэн хуваарь гаргах, мэдээллийг цахимжуулах, товхимол гаргах
- 3.3.29. Сумдын онцлогт тулгуурлан үндэстэн, ястны бренд, органик хоол хөтөлбөрийг хэрэгжүүлэх
- 3.3.30. Аялал жуулчлалын бүтээгдэхүүн хөгжүүлэлтийг орон нутгийн даац нөөцийн зохистой харьцаанд тулгуурлаж боловсруулж, бүсчлэн хөгжүүлэх
- 3.3.31. Аяллын бүтээгдэхүүн, маршрутыг Тур компаниудтай хамтран голлох зах зээлд зориулан шинэчлэн боловсруулах
- 3.3.32. Түүх, соёлын танин мэдэхүйн аялал жуулчлалын бүтээгдэхүүн, маршрутыг боловсруулж цахимжуулж аймаг орон нутгаа сурталчлах

3.3.33. Байгалийн, тусгай сонирхлын болон адал явдалт аялал жуулчлалын хөтөлбөрийг боловсруулж олон нийтэд сурталчлах

3.3.34. Соёлын аялал жуулчлалын хөтөлбөрийг боловсруулах ажлыг зохион байгуулах

3.3.35. Аялал жуулчлалын улирлын хамаарлыг бууруулах зорилгоор хурал, семинар, үзэсгэлэн, яармагийн аялал жуулчлалыг хөгжүүлэх зохион байгуулах

3.3.36. Эрүүл мэнд, сэтгэл засал, рашаан сувиллын аялал жуулчлалыг бүсчлэн хөгжүүлэх ажлын судалгааг мэргэжлийн байгууллагатай хамтран хийх ажлыг эхлүүлэх

3.3.37. Хил орчим болон хил дамжсан аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар судалгаа хийх

3.3.38. Жуулчдад зориулсан "Тал нутгийн нүүдэлчдийн их өв соёл" эвент арга хэмжээг урд бүсийн сумдад жил бүр ээлжлэн зохион байгуулах

3.3.39. Төр нийгмийн нэрт зүтгэлтэн Дансранбилэгийн Догсомын нэрэмжит "Хөх торгон дээл" ардын дууны уралдаан / Баян-Овоо сум /

3.3.40. ЗХУ-ын болон МУ-ын СТА, дипломатич Хорлоогийн Ёндонгийн нэрэмжит "Монгол бүжгийн гайхамшиг" бүжгийн уралдаан зүүн бүсийн хэмжээнд / Баян-Овоо сум /

3.3.41. "Гүрэмийн мөнгөн талст" мөсний наадам / Баян-Овоо сум /

3.3.42. Түүхэн аялал жуулчлалын брэнд бүтээгдэхүүний ном гаргах ажлын хэсгийг байгуулах эхлүүлэх

3.3.43. Монгол улсын Төрийн шагналт Яруу найрагч Р.Чойномын гэр музейн үзмэрийг баяжуулах / Дархан сум /

3.3.44. Их Эзэн Чингис хаан цогцолборт дагаж мөрдөх ёс жаягыг боловсруулж батлуулах, Монгол улсын үндэсний эвент болгох

3.3.45. Мөсөн шагайн наадмыг тогтмол зохион байгуулах /Хэрлэн, Биндэр, Дадал /

3.3.46. Өвгөн ноён Пүрэвжавд зориулсан уран сайхны кино бүтээх судалгааг хийх

**3.4. "Аялал жуулчлалын салбарт дэвшилтэт технологийг нэвтрүүлэн цахим аялал жуулчлалыг хөгжүүлж, чанар, хүртээмжийг сайжруулах" зорилтын хүрээнд:**

3.4.1. Цахим аялал жуулчлал-хөтөч хөтөлбөр хэрэгжүүлэх

3.4.2. [www.travelhubmongolia.com](http://www.travelhubmongolia.com) аялал жуулчлалын цахим хүний нөөцийн мэдээллийн сангийн хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлэх мэдээллийг тогтмол явуулах

3.4.3. Airbnb, what3words зэрэг зочид буудлын цахим сүлжээнд зочид буудал, жуулчны бааз, дэн буудлуудын мэдээллийг байршуулах ажлыг дэмжих

3.4.4. Жуулчдад зориулсан хөтөч гар утасны аппликейшн хөгжүүлэх, олон нийтэд сурталчлан таниулах ажлыг зохион байгуулах

3.4.5. Цахим-аялал жуулчлалын бизнесийг хөгжүүлэх;

3.4.6. Tripadvisor.com цахим мэдээллийн санд дүн шинжилгээ хийх, мэдээллийг тогтмол оруулах;

3.4.7. Аялал жуулчлалын блог хөтлөх;

**3.5. "Аялал жуулчлалын салбарын судалгаа шинжилгээ, мэдээллийн тогтолцоог сайжруулж дотоод, гадаад хамтын ажиллагаа, маркетинг сурталчилгааг эрчимжүүлэх" зорилтын хүрээнд:**

3.5.1. Аялал жуулчлалын салбарын статистик бүртгэл, мэдээллийг боловсронгуй болгох

3.5.2. Аялал жуулчлалын салбарын судалгаа шинжилгээг мэргэжлийн байгууллагатай хамтран хийх

3.5.3. Аялал жуулчлалыг гадаад, дотоодод сурталчлах нэгдсэн бодлого, төлөвлөгөө боловсруулах ажлын хэсгийг байгуулж хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах



3.5.4. Аялал жуулчлалын салбарын байгууллагуудын сургалт, уулзалтыг тогтмол зохион байгуулах харилцан туршлага судлах

3.5.5. ОУ-ын болон голлох зах зээлийн орнуудын урлаг, соёлын одуудтай хамтран ажиллаж бүтээгдэхүүнээ сурталчлах ажлыг зохион байгуулах

3.5.6. Аялал жуулчлалын ач холбогдол бүхий газруудыг google map дээр байршуулах мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах

3.5.7. Гадаад, дотоод сурталчилгааны зурган болон видео контент мэдээллийг цуглуулах, боловсруулан, хэвлүүлэх

3.5.8. Голлох зах зээлийн орнуудын олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнгүүд (ITB Берлин, ITB Монгол, Торгоны зам, Цайны зам, GTI хөтөлбөр гэх мэт)-д оролцох туршлага судлах

3.5.9. Хөрш орнуудын зах зээлд нэвтрэх, олон улсын аялал жуулчлалын сүлжээнд нэгдэх, аялал жуулчлалын бүтээгдэхүүн борлуулалтын сувгуудыг төлөвлөж хэрэгжүүлэх

3.5.10. Аялал жуулчлалын Үндэсний болон олон улсын хурал, уулзалтуудыг зохион байгуулах зорилгоор гадаад, дотоодын аялагчдыг татах

3.5.11. Аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг сурталчилсан реалити шоу зохион байгуулах, медиа контент боловсруулах олон нийтэд хүргэх ажлыг зохион байгуулах

3.5.12. Хэвлэл мэдээллийнхэнд зориулсан аялал жуулчлалын хөгжлийн талаарх нэвтрүүлэг бэлтгэх, сурталчлах

3.5.13. Аялал жуулчлалын голлох зах зээлийн нарийвчилсан судалгааг мэргэжлийн байгууллагаар хийлгүүлэх ажлын төлөвлөгөө гаргах

3.5.14. Аялал жуулчлалын видео танилцуулга бэлтгэх олон нийтийн сүлжээнд байршуулан аймаг орон нутгаа сурталчлах

3.5.15. Олон нийтийн сүлжээн дэх маркетинг сурталчилгааг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах

**3.6. “Нутгийн иргэдийн оролцоотой тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлж иргэдийн амьжиргааг сайжруулж орон нутгийн нийгэм, эдийн засгийн өгөөжийг нэмэгдүүлэх” зорилтын хүрээнд:**

3.6.1. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нийлүүлэлтийн төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх

3.6.2. Нутгийн иргэдэд түшиглэсэн, нүүдэлчин соёлыг харуулсан аялал жуулчлалыг хөгжүүлэх

3.6.3. Аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгжүүдэд аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээ, хөгжүүлэлтийн сургалт зохион байгуулах, дэмжлэг үзүүлэх

3.6.4. “Чингис хаан”, “Их хуралдайн орд өргөө”, “Тэнгэрийн Андгай”, “Шихихутаг-Нууц товчоо” цогцолбор, “Монголын Далд уурхайн музей, сургалт, судалгаа, аялал жуулчлалын төв”, “Монголын нууц товчоо”, “Хар зүрхний хөх нуур” зэрэг бэлэг, дурсгалын бүтээгдэхүүний төслийг хэрэгжүүлэх ажлын хэсгийг байгуулах бэлэг дурсгалын бүтээгдэхүүнийг гаргах

3.6.5. Органик хүнс ба хүлэмжийн аж ахуйн төсөл хэрэгжүүлэх

3.6.6. Усалгаатай тариалан төсөл хэрэгжүүлэх

3.6.7. Зөгийн аж ахуйн төсөл хэрэгжүүлэх

3.6.8. Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэх төсөл хэрэгжүүлэх

3.6.9. Махны чиглэлийн ФАА хөгжүүлэх

3.6.10. Арьс шир боловсруулах үйлдвэрлэлийн төсөл хэрэгжүүлэх

3.6.11. Ус, жимсний шүүс бэлтгэх, савлах

3.6.12. Жимс, жимсгэнэ тариалах төсөл

3.6.13. Ноос, ноолуурын боловсруулах үйлдвэр байгуулагдахад дэмжлэг үзүүлэх  
3.6.14. Цэцэрлэгжүүлэлт, ойжуулалтын бизнесийн төсөл хэрэгжүүлэх  
3.6.15. Нийтийн тээврийн үйлчилгээг нэмэгдүүлэх, үйлчилгээг сайжруулах  
3.6.16. Эко сав баглаа боодлын бизнес хөгжүүлэх ажлыг зохион байгуулах  
3.6.17. Аялал жуулчлалыг хөгжүүлэх сан байгуулах  
3.6.18. Нутгийн иргэдийн соёлыг хамгаалах, өв соёлын талаар сургалт зохион байгуулах

3.6.19. Гадаад хэлний (Англи, Франц, Хятад, Солонгос, Орос, Герман) хөтөлбөрүүдийг дунд сургуулиудад эрчимжүүлэх

3.6.20. Хүүхэд, залуучууд, иргэдэд зориулсан байгаль орчин ба аялал жуулчлалын боловсролын хөтөлбөр хэрэгжүүлэх /Цас мөсний баяр, Автобустай аялал зохион байгуулах/

3.6.21. Барилгын материалын үйлдвэрлэл хөгжүүлэх төсөл хэрэгжүүлэх ажлыг судлах

**3.7. “Аялал жуулчлалын сайн засаглал, шилдэг менежментийг бэхжүүлэх” зорилтын хүрээнд:**

3.7.1. Цогцолборуудын менежментийн бүтцийг бий болгож хэрэгжүүлэх

3.7.2. Аялал жуулчлалын салбарын хүний нөөцийн бодлого, төлөвлөлтийг боловсруулж, хэрэгжилтийг хангаж ажиллах

3.7.3. Аялал жуулчлалын цогцолбор, төвүүдийн бизнес төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах

3.7.4. Байгаль орчин, аялал жуулчлалын салбарт мөрдөгдөж буй хууль тогтоомж, аялал жуулчлалын салбарын хөгжил сургалтуудыг тогтмол зохион байгуулах

3.7.5. Гадаад, дотоодын хамтын ажиллагааг эхлүүлэх, эрчимжүүлэх

3.7.6. Гурван нуур, Цагаан нуур, Тосон нуур, Гүрмийн нуур, Хөх нуур болон нуур, цөөрмийн эхийг хамгаалах төслүүдийг хэрэгжүүлэх, байгаль орчин, физик химийн нарийвчилсан үнэлгээ, судалгааны ажлыг эхлүүлэх

3.7.7. Ойн санг хамгаалах, нэмэгдүүлэх төсөл хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах арга хэмжээг авах

3.7.8. Рашаан хад–Дэлхийн өвд бүртгүүлэх судалгааны ажлыг эрчимжүүлэх мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах

3.7.9. Байгаль, түүхийн онцгой нутгуудыг улсын болон орон нутгийн хамгаалалтанд оруулах ажлыг зохион байгуулах

3.7.10. Түүх, археологи, соёлын өвийг хамгаалах, сэргээх, сурталчлах чиглэлээр төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, төслийн саналуудыг боловсруулах, санхүүжилт төвлөрүүлэх ажлыг судлан хэрэгжүүлэх

3.7.11. Түүхэн аялал жуулчлалыг хөгжүүлэх хөтөлбөрийг үе шат бүрт үйл ажиллагааны дэлгэрэнгүй төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлж, үр дүнг үнэлэх

3.7.12. Ховор, нэн ховор ургамлыг хамгаалах үржүүлэх генетик фондыг хамгаалах төслийг хэрэгжүүлэх

### **ДӨРӨВ. ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН**

1. Чингис хааны өв, соёлын хүрээлэнгийн үйл ажиллагаа үргэлжилж түүхэн аялал жуулчлалын эрх зүйн орчинг бүрдүүлсэн байна.

2. Түүхэн аялал жуулчлалын 5 цогцолбор баригдаж дэд бүтэц бүрэн шийдэгдсэн байна.

3. Аялал жуулчлалын бүтээгдэхүүн хөгжүүлэлтийг сайжруулж, хүний нөөцийг нэмэгдүүлэн чадавхжуулж, соёлын аялал жуулчлалыг хөгжүүлж, жуулчдын зорин ирэх бүс нутаг болсон байна.

4. Цахим аялал жуулчлалыг олон улсын түвшинд хөгжүүлэн мэдээ мэдээллийг түгээж гадаад, дотоодын жуулчдыг хүлээн авах боломжийг нэмэгдүүлэн ирэх жуулчдын тоог 140.000-д хүргэсэн байна.

5. Аялал жуулчлалын салбарын статистик бүртгэл, судалгааг боловсронгуй болгож маркетинг сурталчилгааг олон улсын түвшинд эрчимжүүлж гадаад, дотоодын хамтын ажиллагааг нэмэгдүүлнэ.

6. Нутгийн иргэдийн оролцоотой тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх шинээр 5600 ажлын байрыг бий болгон орон нутгийн нийгэм, эдийн засгийн өгөөжийг нэмэгдүүлдсэн байна.

7. Түүх, соёлын өвд түшиглэсэн, менежментийн шинэчлэлийг хэрэгжүүлсэн, аялал жуулчлалын чиглэлээр төрөлжсөн, ногоон хот суурин газрыг хөгжүүлсэн байна.

#### **ТАВ. ХӨТӨЛБӨРИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

5.1. Хөтөлбөрийн үйл ажиллагааны нэгдсэн удирдлага зохицуулалтыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс хариуцна.

5.2. Хөтөлбөрийн үйл ажиллагааны хэрэгжилтийг Холбогдох яам, агентлаг, Сумдын Засаг даргын Тамгын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар хамт хангаж ажиллах ба ажлын явц, хэрэгжилтийг нэгтгэн үр дүнг тооцох, тайлагнах ажлыг Байгаль орчин, аялал жуулчлалын газар гүйцэтгэнэ.

#### **ЗУРГАА. ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮР ДҮН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ**

6.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг зорилт, үйл ажиллагааны үр дүнгээр үнэлнэ.

6.2. Хөтөлбөрийн хэрэгжилтэд аймгийн Засаг даргын Тамгын газар жил бүр хяналт тавьж ажиллана.